



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2019

Э-сонин

3-Р САР

68-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2019.03.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	20
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	32,176,110,958.91
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	28,929,107,328.91
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	3,247,003,630
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	112,957,264
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	112,923,390
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	33,874
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	6,774


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	216
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	11
Хувийн өмчийн	187
I ангилал	13
II ангилал	42
III ангилал	167

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	61
Үүнээс: Брокер, Дилер	52
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.03.31-ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Голомт Капитал ХХК	28,921,791	19,064,765,909	27,094,070	18,814,450,048	37,879,215,956
2	Ард капитал групп ХХК	24,321,335	2,456,944,033	70,927,163	6,208,146,365	8,665,090,398
3	Тэнгэр капитал ХХК	182,013	1,816,412,932	33,488	1,802,495,199	3,618,908,131
4	Ард секюритиз ХХК	25,151,156	2,504,813,937	1,520,476	548,890,579	3,053,704,516
5	Бумбат-Алтай ХХК	2,685,412	1,505,487,552	2,160,489	1,516,266,989	3,021,754,541
6	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	2,673,001	1,154,059,254	2,459,098	1,517,496,118	2,671,555,372
7	БиДиСек ХК	8,815,707	862,088,692	2,474,405	471,096,943	1,333,185,635
8	Новел инвестмент ХХК	1,942,693	771,528,200	585,801	94,667,266	866,195,466
9	Стандарт инвестмент ХХК	7,077,790	668,781,767	1,176,393	191,184,691	859,966,458
10	Ти Ди Би Капитал ХХК	1,585,413	246,128,575	616,610	176,795,706	422,924,282
11	Апекс Капитал ҮЦК	1,300,466	216,140,453	321,311	166,859,215	382,999,668
12	Гранддевелопмент ХХК	1,348,864	163,467,320	59,869	20,999,358	184,466,678
13	Монсек ХХК	632,452	61,922,047	776,286	119,720,687	181,642,734
14	Гендекс ХХК	86,061	6,970,941	293,742	164,910,270	171,881,211
15	Гаули ХХК	629,677	83,565,452	149,352	82,681,149	166,246,601
16	Зэргэд ХХК	1,449,505	135,374,499	166,978	21,177,900	156,552,399
17	Блүмсбюри секюритиес ХХК	941,324	107,374,565	124,054	13,059,246	120,433,812
18	Тулгат чандмань баян ХХК	991,406	88,994,968	216,517	25,663,393	114,658,360
19	Таван богд ХХК	371,356	30,965,006	461,516	54,639,031	85,604,037
20	Гүүдсек ХХК	115,502	10,803,203	767,628	51,905,925	62,709,127

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.03.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	APU	АПУ	26,618,588	19,076,932,625	650	610	0.79	672.16
2	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	1402613	1363295630	930	850	-3.53	13.97
3	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	6,208,319	549,229,432	93	80	0.60	22.82
4	SHG	ШАРЫН ГОЛ	305,826	492,759,423	1,955	1,610	15.00	19.88
5	AIC	АРД ДААТГАЛ ХК	694,479	481,336,133	700	620	-1.58	17.20
6	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	63338	322409640	5350	5000	1.39	31.96
7	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	4,210,248	285,821,181	72	65	1.87	55.46
8	GOV	ГОВЬ	683,533	214,862,587	324	290	-9.59	229.04
9	TTL	ТАВАН ТОЛГОЙ	23,691	169,898,800	7,450	7,010	1.40	380.51
10	JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	678010	101701550	155	150	3.33	0.81
11	TUM	ТҮМЭН ШУВУУТ	535964	94889302.17	201	169.2	-14.94	33.97
12	JIV	ЖИНСТ-УВС	54402	93627116	2000	1471	16.35	3.30
13	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	157,132	74,416,238	530	472	-5.69	17.36
14	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	247,452	61,514,811	259	241	-1.20	13.93
15	MIB	МОНИНЖБАР	510,738	51,073,482	100	99	5.26	1.59
16	MNP	МОНГОЛ ШУУДАН	87,027	47,664,283	655	490	9.60	58.83
17	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ	62,248	32,681,837	570	515	-0.88	2.06
18	GTL	ГУТАЛ	1720	29669200	19550	16000	-5.59	25.98
19	ITLS	АЙТҮҮЛС	234,841	21,922,667	100	91	-7.10	3.20
20	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	165	20,994,700	138,000	122,000	-9.54	8.18



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.03.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2019-03-01	2019-03-31		
1	МОНГОЛ НЭХМЭЛ	204	1,801.00	2,735.00	934.00	51.86
2	БАЯН-АЛДАР	197	700.00	1,001.00	301.00	43.00
3	АДУУН ЧУЛУУН	124	1,550.00	1,975.00	425.00	27.42
4	ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ	2	820.00	1,000.00	180.00	21.95
5	ЖИНСТ-УВС	54,402	1,700.00	1,978.00	278.00	16.35
6	ШАРЫН ГОЛ	305,826	1,700.00	1,955.00	255.00	15.00
7	НАКО ТҮЛШ	521	100.00	115.00	15.00	15.00
8	БАЯНТАЛБАЙ	1	65.00	74.75	9.75	15.00
9	ХҮРД	4	2,447.00	2,814.00	367.00	15.00
10	ТАХЬ-КО	3	12,060.00	13,860.00	1,800.00	14.93
11	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	11	2,040.00	2,340.00	300.00	14.71
12	МЕРЕКС	14	24.50	28.10	3.60	14.69
13	ДАРХАН ХӨВӨН	2	9,000.00	10,000.00	1,000.00	11.11
14	МОНГОЛ ШУУДАН ХК	87,027	538.97	590.71	51.74	9.60
15	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	808	432.94	471.55	38.61	8.92
16	ОЛЛОО	6	74.70	80.00	5.30	7.10
17	МОНИНЖБАР	510,738	95.00	100.00	5.00	5.26
18	ТӨМРИЙН ЗАВОД	215	7,800.00	8,190.00	390.00	5.00
19	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	3,587	300.00	315.00	15.00	5.00
20	ГАН ХЭРЛЭН	36	5,070.00	5,320.00	250.00	4.93

Ханшийн бууралттай хувьцаа

/2019.03.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2019-03-01	2019-03-31		
1	ТЕХНИК ИМПОРТ	12	17,900.00	13,830.00	-4,070.00	-22.74
2	ДӨРВӨН-УУЛ	12	1,350.00	1,050.00	-300.00	-22.22
3	ХЭРЛЭН ХИВС	964	87.00	68.00	-19.00	-21.84
4	БАЯЛАГ НАЛАЙХ	2,720	410.50	333.00	-77.50	-18.88
5	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	320	34,000.00	28,160.00	-5,840.00	-17.18
6	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	220	300.00	250.00	-50.00	-16.67
7	ХАЙ БИ ОЙЛ	161	60.00	50.00	-10.00	-16.67
8	АВТО ЗАМ	38	4,500.00	3,800.00	-700.00	-15.56
9	БАГАНУУР	3,922	1,300.00	1,105.00	-195.00	-15.00
10	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	146	120.00	102.00	-18.00	-15.00
11	БИНСЭ ХК	10	400.00	340.00	-60.00	-15.00
12	ТҮМЭН ШУВУУТ	535,964	199.71	169.87	-29.84	-14.94
13	ХӨХ ГАН	17,698	70.00	60.00	-10.00	-14.29
14	БАЯНТЭЭГ	5	27,400.00	24,000.00	-3,400.00	-12.41
15	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	85	1,025.00	900.00	-125.00	-12.20



"ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХОНХ ЦОХИХ ЁСЛОЛ" БОЛЛОО

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК нь Олон Улсын Санхүүгийн Корпораци /ОУСК/, НҮБ-ын Глобал Компактын Монгол Улс дахь сүлжээ байгууллага, МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран **"Жендерийн тэгш байдлын төлөө хонх цохих"** ёслолын арга хэмжээг 3 дахь жилдээ зохион байгуулж, үнэт цаасны 5925 дахь удаагийн арилжааг нээлээ.

Жил тутам зохион байгуулдаг тус арга хэмжээ нь бизнес болон тогтвортой хөгжилд жендерийн тэгш байдлын чухлыг олон нийтэд таниулах зорилготой бөгөөд дэлхийн 80 гаруй хөрөнгийн биржүүд тус арга хэмжээнд нэгддэг байна.

Монголын хөрөнгийн бирж нь гүйцэтгэх болон удирдах түвшний ажлын байранд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжиж, жендерийн тэгш байдлыг хангахад анхааран ажилладаг бөгөөд цаашид ч энэхүү зарчмыг баримтлан ажиллах болно.

ӨВӨРХАНГАЙ, БАЯНХОНГОР АЙМАГТ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК, "Арилжааны төлбөр тооцооны төв" ТӨХХК, МХБ-ийн гишүүн компаниуд болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-тай хамтран "Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг" арга хэмжээг Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 2019 оны 3 дугаар сарын 4-нөөс 3 дугаар сарын 8-ний өдрүүдийн хооронд зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулснаас гадна "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, үнэт цаасны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэргээр нийт 2,000 гаруй иргэдэд нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ. МХБ нь 2018-2019 онд нийт 11 аймагт тус арга хэмжээг амжилттай зохион байгуулаад байгаа бөгөөд цаашид Монгол Улсын бусад 10 аймагт уг арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

"МОНОС ХҮНС" КОМПАНИ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/138 тоот тушаалаар "Монос Хүнс" ХХК-ийн нийт

408,850,428 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн II ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцэж, 28 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 30 хувь буюу 122,655,128 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 70 төгрөгийн тогтоосон үнээр стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрлөө.

Тус компани олон нийтэд санал болгон худалдах нийт хувьцааны 50 хувь буюу 61.3 сая ширхгийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн 50 хувь буюу 61.3 сая ширхгийг нийтэд санал болгон худалдаж, нийт 8.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Энэхүү хувьцааны андеррайтингийн үйлчилгээг "Голомт Капитал ҮЦК" ХХК, аудитын үйлчилгээг "Грант торнтон" ХХК, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг "Өмгөөллийн И Эл Си" ХХН, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээг "Итгэлт-Эстимэйт" ХХК тус тус үзүүлж байна.

"АРД КРЕДИТ ББСБ" ХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА НИЙЛҮҮЛТЭЭСЭЭ ДАВЖ ХААГДЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2019 оны хоёр дахь ІРО болох "Ард Кредит ББСБ" ХК нь нийт хувьцааны 25% буюу 70,000,000 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийт санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс өнөөдөр буюу 3 дугаар сарын 1-ний өдрийн 17:00 цаг хүртэл авч дууслаа.

"Ард Кредит ББСБ" ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад нийт 1,763 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож нийт 7,318,438,999 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон татан төвлөрүүлэх доод дүнгээс 3 дахин давсан үзүүлэлт боллоо.

"Ард Кредит ББСБ" ХК нь шинээр олон нийтэд санал болгож байгаа 35 сая ширхэг үнэт цаасыг МХБ-ийн "Анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын Захиалга бүртгэлийн аргыг ашиглан 70-85 төгрөгийн хооронд санал болголоо. Захиалгын дийлэнх нь 85 төгрөгөөр ирсэн хэдий ч үнэт цаас гаргагч "Ард Кредит ББСБ" ХК болон андеррайтерийн компани болох "Ард Капитал ҮЦК" ХХК-ийн зүгээс МХБ-ийн журам, хөрөнгө оруулагчдад өгөх өгөөжийг харгалзан үзэж нэгж хувьцааны нийлүүлэх үнийг нийт ирүүлсэн захиалгын тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханш буюу 81 төгрөгөөр тогтоохоор шийдвэрлэлээ. Тогтоосон ханшнаас доогуур захиалга өгсөн оролцогчдын захиалга биелэх боломжгүй бөгөөд 81 төгрөгөөс дээш өгсөн захиалгыг журмын дагуу 43.73 хувиар хувь тэнцүүлэн тооцож хуваарилалт хийлээ.



НЭР БҮХИЙ 21 ХУВЬЦААТ КОМПАНИЙГ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг хангуулах замаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа билээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд, МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлага хангахгүй байгаа хувьцаат компаниудад хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгч, заасан хугацаанд холбогдох зөрчлийг арилгаагүй компаниудыг бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээг авч байгаа болно. Үүний дагуу, үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 1 жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилаагүй дараах нэр бүхий 21 компанийг Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.10 дахь заалтууд, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23 дугаар зүйлийн 23.11.4 дэх заалтыг тус тус үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн А/20 тоот тушаалаар Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа. Үүнд:

№	Компанийн нэр	Үсгэн код	Тоон код
1	"Еврофё Азия" ХК	SOI	37
2	"Мон-Асар" ХК	ASA	50
3	"Харгиа" ХК	HAG	365
4	"Сав шим" ХК	GTU	424
5	"Алмаас" ХК	ALM	333
6	"Баянтоорой" ХК	BTR	296
7	"Мөнх жим" ХК	AZA	130
8	"Өв-Усжуулагч" ХК	UAA	212
9	"Төв Ус" ХК	UST	421
10	"Хангал" ХК	HGL	372
11	"Чандмань уул" ХК	CAD	181
12	"Харшийн гэгээ" ХК	AVH	161
13	"Баялаг шарын гол" ХК	BLS	256
14	"Ар тархи" ХК	ART	403
15	"Бүтээл" ХК	BUT	395
16	"Дорнод тээвэр" ХК	DOT	358
17	"Жинет" ХК	JST	230
18	"Их нуур" ХК	INH	157
19	"Их үүсгэл" ХК	IHU	185
20	"Сэлэнгэ импекс" ХК	SEM	449
21	"Чандмань Дундговь" ХК	CDU	352

Үйл явдал

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" КОМПАНИ ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хороо "Эрдэнэс Тавантолгой" компанийг хаалттай хувьцаат компаниар бүртгэж, хувьцааг хадгаламжид бүртгэхийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д зөвшөөрлөө. УИХ-аас 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс өмнө төрсөн Монгол Улсын нийт иргэдэд "Эрдэнэс Тавантолгой" компанийн 1072 ширхэг хувьцааг үнэ төлбөргүй эзэмшүүлэх шийдвэрийг гаргасан бөгөөд Засгийн газар 2012 онд уг хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд саналын эрхгүй, Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлийг тогтоож өгсөн юм. "Эрдэнэс Тавантолгой" ХК нь УИХ, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу хөрөнгийн биржид бүртгэгдэж, **нээлттэй хувьцаат компани** болсноор иргэд өөрийн эзэмшиж байгаа хувьцааг худалдах эсвэл нэмж худалдан авах, бусдад шилжүүлэх, өвлүүлэх эрх үүсэх юм.

"БАЯН-АЛДАР" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

"Баян-Алдар" ХК-д "Монгорүматрикс Гинко" ХХК-г нэгтгэх үйл явцтай холбогдох өөрчлөлтийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 20 тоот албан шаардлагын дагуу "Баян-Алдар" ХК-ийн үнэт цаасны арилжааг 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн нээлээ.

"БАЯН-АЛДАР" ХК-ИЙН ОНООСОН НЭРИЙГ "БАЯН-АЛДАР ББСБ" ХК БОЛГОН ӨӨРЧИЛЛӨӨ

"Баян-Алдар" ХК-ийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 56 тоот албан хүсэлт, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн дүрмийн 8.10.11 заалт, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн гаргасан Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/24 тоот тушаалаар "Баян-Алдар" ХК-ийн оноосон нэрийг "Баян-Алдар ББСБ" ХК болгон өөрчиллөө.

"АРД ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Ард даатгал" ХК-ийн 2019 оны 4 сарын 27-ны өдрийн 09 цагт болох Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын байршил өөрчлөгдөж, "Зайсан хилл" цогцолборын хурлын танхимд зохион байгуулагдахаар болсон байна.



"БАРИЛГА КОРПОРАЦИ" ХК НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХААР БОЛЛОО

"Барилга Корпораци" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн №02 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 985 төгрөг буюу нийт 40.0 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөр тасалбар болгож гаргах бөгөөд ногдол ашгийг компанийн байранд бэлэн мөнгөөр олгох тухай мэдэгдлээ.

"ТАЛЫН ГАЛ" ХК НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

"Талын гал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 50 төгрөг буюу нийт 34.7 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөр тасалбар болгож гаргах бөгөөд ногдол ашгийн төлбөрийг компанийн байранд болон ҮЦТХТ-өөр дамжуулан олгохоор болсон байна.

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИЙН"- ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй, Монгол Улсад хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" (Т SX: ERD | MSE: ERDN) нь Торонтогийн хөрөнгийн биржид 11,014,544 ширхэг үнэт цаасыг нэмэлтээр бүртгүүлж, нэг бүрийг нь 0.23 канад доллараар хаалттай хүрээнд санал болгон худалдаж, нийт 2,533,345 канад долларын хөрөнгийг татан төвлөрүүлсэн байна.

Тус компани нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг Хөндий Алтны Төслийн Урьдчилсан Техник Эдийн Засгийн Үндэслэлийг боловсруулах, ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах, Монгол Улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас олгож эхэлсэн тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцох, компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байна.

"ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

"Хөвсгөл Геологи" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 100 төгрөг буюу нийт 14.4 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Үйл явдал

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоож, 2019 оны 4-р сарын 29-ний өдрөөс эхлэн "ҮЦТХТ" ХХК-д байрших хувьцаа эзэмшигчдийн дансаар дамжуулан олгохоор шийдвэрлэсэн байна.

"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК НОГДОЛ АШИГ ХУВААРИЛНА

"Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 03/03 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 төгрөг 10 мөнгөний ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр, ногдол ашиг төлөх өдрийг 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдөр байхаар тус тус тогтоосон байна.

"БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Баянгол Зочид буудал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн №6/19 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 355 төгрөг буюу нийт 150.1 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 9-р сарын 1-ний өдрөөс эхлэн компанийн байранд бэлнээр тараахаар шийдвэрлэсэн байна.

"АДУУНЧУЛУУН" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

"Адуунчулуун" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн №19/03 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 130 төгрөг буюу нийт 409.7 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоож, 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн дотор "ҮЦТХТ" ХХК-д байрших хувьцаа эзэмшигчдийн дансаар дамжуулан олгохоор шийдвэрлэсэн байна.

"ХӨВСГӨЛ ХҮНС" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

"Хөвсгөл Хүнс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 10 төгрөг буюу нийт 2.6 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоож, 2019 оны 5-р сарын 15-ны өдрөөс эхлэн "ҮЦТХТ" ХХК-д байрших хувьцаа эзэмшигчдийн дансаар дамжуулан олгохоор шийдвэрлэсэн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN